



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/268

Хэрлэн сум

“Иргэдийн төсөв-2023” эмхэтгэлийг  
хэвлүүлэхэд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төсвийн талаарх мэдээллийг орон нутгийн иргэдэд ил тод нээлттэй мэдээлэх, нутгийн захиргааны байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах, төсвийн үр ашигтай зарцуулалтад иргэдийн хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор “Иргэдийн төсөв-2023” эмхэтгэлийг хэвлүүлэхэд 800,000 (найман зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны  
дугаар сарын 07-ны өдрийн  
дугаар захирамжийн хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэгж дүн	Нийт дүн
1	"Иргэдийн төсөв-2023" эмхэтгэл	200	4000	800,000
Нийт				800,000